



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 15 өдөр

Дугаар А/137

Булган сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр батлах тухай 2020 оны II/04 дүгээр тогтоол, 2021 оны III/05 дугаар тогтоол, 2023 оны XIV Хуралдааны “Булган аймгийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 14/01 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2023 оны “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг санхүүжүүлэх тухай” захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн багш, оюутнуудыг шинэ техник, технологитой танилцах, туршлага судлах арга хэмжээг Дархан уул, Орхон аймагт зохион байгуулсугай.

2. Туршлага судлах арга хэмжээнд шаардагдах 691,000 (зургаан зуун ерэн нэгэн мянга) төгрөгийг “Шинэ багш” хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ